



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 02/03

Эрдэнэт


Газрын харилцааны талаар
2021 онд баримтлах үйл ажиллагааны
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2"з" дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт. Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Газрын харилцааны талаар 2021 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг хоёрдугаар, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтийн явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хагас жилээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга С.Батжаргалд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

079130039